



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 6/22

Мандалговь


Албан хаагчдыг ажилд
томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 4 дүгээр хавсралт, 6 дугаар хавсралт, 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 2022 оны 488 дугаар тогтоолын 2,5 дугаар хавсралт, 489 дүгээр тогтоол, 2022 оны 491 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны "Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 469 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 18 -ны өдрийн А/18 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан бүтэц орон тооны дагуу тус байгууллагын албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталж үүрэгт ажилд нь томилсугай.

2. Томилогдсон албан хаагчдыг Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын дагуу цалинжуулж, төрийн захиргааны албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдлийг сар бүр 20 хувиар тооцож, бусад нэмэгдлүүдийг хууль тогтоомжийн дагуу бодож, 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн олгохыг ахлах нягтлан бодогч (Б.Энхдөл)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2021 оны Б/30 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Б. МӨНХЖАРГАЛ



48:33 123